



**МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,  
Утас: 264216, Факс: 264460,  
E-mail: info@csc.gov.mn

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Ц.ЦЭНГЭЛ ТАНАА**

2019.11.12 № 05/1401  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тогтоол хүргүүлэх тухай**

Тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан тогтоолыг үүгээр хүргүүлэв.

Тогтоолын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахыг чиглэл болгож байна.

Хавсралт 2 хуудастай.

ГИШҮҮН



Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

19001812



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн  
салбар зөвлөл байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5, 5.6, 5.7, 5.11, 5.12 дахь заалт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.8, 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэд дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл.

Гишүүд:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин;  
Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Т.Булган;

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга П.Цогтсайхан;

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга В.Жавзан;

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга С.Гантулга;

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Сав газрын удирдлагын хэлтсийн дарга Н.Баттулга;

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн Салбар эрхзүйн системчлэл,

ТАЗ тогтоол 2019

19000085

боловсруулалт, хяналт, эрхзүйн зөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Номин-Эрдэнэ

Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын хүний нөөц, нууцын асуудал, төрийн албаны салбар зөвлөл, шагнал, ~~...~~ хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Бадамдулам.

2.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл байгуулснаас бусад харьяа байгууллагын хүний нөөцийн асуудлыг тус салбар зөвлөлд хариуцуулахаар тогтоосугай.

3.Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга / Ц.Цэнгэл/-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишгийг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 194 дүгээр тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 1110 дугаар тушаал, “Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2016 оны 111 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ